



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/415

Мандалговь

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын
салбар зөвлөл байгуулах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:

Гишүүнд:

Засаг даргын орлогч

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого

төлөвлөлтийн хэлтсийн дарга

Цагдаагийн газрын дарга

Авто тээврийн төвийн дарга

Газрын харилцаа, барилга хот,

байгуулалтын газрын дарга

Мэргэжлийн хяналтын газрын дарга

Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын
дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Мандалговь хотын захирагч

Нарийн бичгийн дарга:

Цагдаагийн газрын Замын цагдаагийн
тасгийн дарга

Хоёр. "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр" (2019-2023), Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоол, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж"-ийг хэрэгжүүлэх чиглэлээр жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг салбар Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт даалгасугай.

488191170

Гурав. Тус үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгаж, үйл ажиллагаа зохион байгуулахад хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ